

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын 13-ний өдрийн 464 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн захирал	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн хүрээнд хийгдэх ажлыг Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн түншүүдийн хооронд байгуулсан зээлийн гэрээнд заасан хугацаанд чанартай гүйцэтгэх, Зээлдэгч, Захиалагчийн нэрийн өмнөөс төслийг хэрэгжүүлэхтэй холбогдох хууль, журмын дагуу явуулах, хэрэгжилтэд хяналт тавих, зээлийн гэрээнд заасан Засгийн газраас хүлээсэн үүргийн биелэлтийг цаг тухайд нь тайлагнах, төслийг үр ашигтай хэрэгжүүлэх, Зээлдэгч, Захиалагч. Гүйцэтгэгч, Зөвлөх, бусад байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох зохицуулалтаар ханган төслийн хэрэгжилтийг хариуцах. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн стратегийн удирдлага, донортой харилцаа, бодлогын шийдвэр, санхүү, хүний нөөц, тайлагналын нэгдмэл байдлыг хангах.
2. Ажлын байрны зорилтууд:	1. Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн түншүүдийн хооронд байгуулсан гэрээ, гэрээнд дагаж мөрдөхөөр заасан холбогдох журмын дагуу төслийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, санхүү болон засаглалыг хянах, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, удирдах; 2. Монгол Улсын Засгийн газар /Зээлдэгч/ болон Хөгжлийн түншүүдийн хооронд байгуулсан зээлийн гэрээнд заасан орон тоогоор Зээлдэгч болон Хөгжлийн түншүүдийн төслийн хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг Хөгжлийн түншүүдийн зээлийн гэрээ, зээл ашиглалт, зөвлөх үйлчилгээ, худалдан авах ажиллагааны хууль журмын дагуу хийж гүйцэтгэх; 3. Төслийн хэрэгжилт, санхүүжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрээр хангах, Захиалагч, талуудыг төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх үнэн зөв бодит

ажиллаж, төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх үнэн зөв бодит мэдээллээр хангаж, хүссэн төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг бэлтгэж өгөх; 5. Төслийн хэрэгжилтийн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг удирдан чиглүүлэх, үр дүнг төслийн захирал, ТУХ-д танилцуулах; 6. Худалдан авалт болон хөрөнгийн урсгалыг Хөгжлийн түншүүдийн журам, Засгийн газрын шаардлагын дагуу зохицуулж байгаа эсэхийг баталгаажуулах, хянах; 7. Бараа, ажил, зөвлөх үйлчилгээний гэрээний хяналт тавьж гүйцэтгэл, хэрэгжилтэд ажиллахад ЭЗХЯ-д бүх талын дэмжлэг үзүүлэх; 8. Төслийн II үе шатыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлуудыг зохион байгуулах, хянах; 9. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны тогтвортой, үр дүнтэй хэрэгжилтэд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Хөгжлийн түншүүдийн худалдан авах бодлого, журамд нийцүүлэн зохион байгуулж хэрэгжүүлж байгаа эсэх, биелэлтэд хяналт тавих; 10. Төслийн урьдчилгаа данс болон бусад дансыг нээх, хөтлөх, тайлагнах зэрэг үйл ажиллагааг хариуцаж ажиллах; 11. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх, гэрээг сунгах, цуцлах болон ажилтныг урамшуулах, санал хариуцлага тооцох талаар боловсруулж төслийн захиралд танилцуулах; 12. Сангийн яаманд нэгтгэгдэх улсын төсөвт төслийн оролцогч талуудын (ЭЗХЯ) хувь нэмэр, оролцоо бүрэн дүүрэн тусгагдсан эсэхэд анхаарах; 13. Төслийн жил, улирлын тайланг Хөгжлийн түншүүдийн төслийн гүйцэтгэлийн менежментийн системд нийцүүлэн боловсруулж хүргүүлэх; 14. Төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг гаргаж баталгаажуулах;		
--	--	--

төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангуулах; 25. Засгийн газраас хүлээсэн үүргийг цаг тухайд нь хэрэгжүүлэхэд бүхий л талын дэмжлэг, зохицуулалтаар хангах; 26. Төслийн хүрээнд нийгэм, жендер, байгаль орчны талаар зайлшгүй хэрэгжүүлэх заалтыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудаар дагаж мөрдүүлж хэрэгжилтийг хангуулах; 27. ЭЗХЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран олон нийтэд чиглэсэн мэдээлэл, харилцааны арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; 28. Төслийн эцсийн тайланг АХБ-ны зааврын дагуу төсөл хэрэгжиж дууссанаас хойш 6 сард багтаан хүргүүлэх. 29. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэрэгжилтийн стратеги, төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хянах; 30. Донор байгууллагууд, Сангийн яам, холбогдох ТЕЗ болон хэрэгжүүлэгч байгууллагуудтай харилцах гол холбоос байх; 31. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүү, худалдан авалт, хяналт-шинжилгээ, тайлагналын уялдааг хангах; 32. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэрэгжүүлж буй дэд төслүүдийн зорилт, шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийн үр дүнг хариуцах; 33. Бүх дэд төслүүдийн уялдаа, нэгдсэн тайлагналыг нэгтгэн дүгнэх.		
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэг хамгаалсан.	
		Мэргэжил	Нягтлан бодох бүртгэл /0411/,	

		Туршлага	Хөдөө аж ахуй, төслийн удирдлага зэрэг салбарт удирдах албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай.	
		Ур чадвар	Албан хэргийн англи хэлний мэдлэгтэй байх.	Хөдөө аж ахуй, дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний талаар ойлголттой байх.
	1.2.Тусгай шаардлага	1. Удирдан манлайлж, шийдвэр гаргах чадвартай; 2. Багаар ажиллах чадвартай; 3. Холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байх		

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2026.01.13

Дугаар: А/04

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

(И.БАТХҮҮ)

2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр

